



ХОВД АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2016 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 2/04

Ховд

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд  
хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "а", 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтыг үндэслэн "Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2017 оны үндсэн чиглэлийг батлах тухай" аймгийн Засаг дарга Д.Галсандондогийн итгэлийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс аймгийн ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүнг хянан шалгах, үнэлэлт дүгнэлт өгөх болон Хөшөөтийн уурхайн МоЭнКо ХХК-ны аймагтай хамтран ажиллах тухай байгуулсан гэрээний биелэлтийг шалган дүгнэх, цаашид гэрээг шинэчлэн байгуулах ажлын хэсгийг тус, тус байгуулан ажиллуулж дүнг аймгийн ИТХ-ын хуралдаанд танилцуулахыг аймгийн ИТХ-ын дарга /Г.Пүрэвганди/-д үүрэг болгосугай.

3. Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт арга хэмжээ бүрийг олон нийтэд өргөнөөр сурталчилж, шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн арга хэмжээний санхүүжилтэд тусган хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Галсандондог/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ  
2017 ОНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

**Нэг. Төрийн удирдлага, эрх зүйн бодлогын хүрээнд:**

**1.1 Төрийн байгуулалтын талаар:**

1.1.1 Иргэдэд үйлчлэх “Нэг цонхны үйлчилгээ”-ний чанар, хүртээмж, шуурхай байдлыг дээшлүүлнэ.

1.1.2 Төрийн албан хаагчдыг сургалтанд хамруулж ур чадвар, чадавхийг дээшлүүлж, үүрэг хариуцлагыг өндөржүүлнэ.

1.1.3 Аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим албан байгууллагуудад ISO-9001 стандартыг нэвтрүүлнэ.

1.1.4 Төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэж, цахим засаглалыг бодитой хэрэгжүүлнэ.

1.1.5 Төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, орон нутгийн хөгжилд оруулах үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

1.1.6 Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлнэ.

1.1.7 Багийн төвийг тохижуулах, засварлах ажлыг иргэд, орон нутгийн оролцоотой шийдвэрлэнэ.

1.1.8 Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын үр дүнг бодлого, төлөвлөлтөнд тусгах, үр дүнтэй ашиглах чадавхийг бүх шатанд бий болгоно.

1.1.9 Шийдвэр гаргахдаа иргэд, олон нийтийн саналыг авч, нийгмийн бүлгүүдийн оролцоонд тулгуурлаж, олонхийн эрх ашгийг дээдэлсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.

**1.2. Эрх зүйн бодлогын талаар**

1.2.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг хамгаалах үйл хэрэгт олон нийтийн оролцоог дэмжих, хууль сахиулах байгууллагуудын чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.2.2. Төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааг ил тод нээлттэй байх, төрийн албаны ёс зүйг баримтлах зарчмыг мөрдүүлэх, авлигын эсрэг тэмцэх үйл ажиллагааг идэвхжүүлнэ.

1.2.3. Авлигагүй, бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд төр, захиргааны байгууллагуудын үүрэг, хариуцлагыг дээшлүүлнэ.

1.2.4. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангаж, “Иргэдийн хяналтын зөвлөл” байгуулж хамтран ажиллана.

1.2.5. Хууль тогтоомжийг сурталчлах тайлбарлан таниулах, эрх зүйн сургалт сурталчилгаа, мэдээллийн ажлыг тогтмол явуулж, иргэдийн нийгмийн амьдралд оролцох эрх, үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.2.6. Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, нийтийн эрх ашигт хамаарах асуудлаар шийдвэр гаргах үйл явцад иргэдийн санал авах, тусгах үндсэн дээр шийдвэрийн бодит хэрэгжилтийг хангана.

1.2.7. Сум, байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтөд мэдээллийн технологи нэвтрүүлэх замаар үйл ажиллагааг нь сайжруулна.

1.2.8. Бизнес эрхлэгчдэд шударгаар өрсөлдөх боломжийг бүрдүүлж, хэрэглэгчийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж, тэдэнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэдэг болно.

1.2.9. Хүний эрхийг хөхүүлэн дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

### **1.3. Гадаад харилцааны талаар:**

1.3.1 Аймгийн гадаад харилцааг өргөжүүлж бизнес эдийн засгийн хамтын ажиллагааг сайжруулна.

1.3.2 Олон улсын байгууллагуудтай харилцах харилцааг бүх талаар дэмжиж, орон нутагт төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтыг татна.

1.3.3 Сум, албан байгууллагуудыг хөрш зэргэлдээ муж, хот, байгууллагуудтай харилцан туршлага солилцох, эдийн засаг, бизнесийн салбарт хамтран ажиллах үйл ажиллагааг дэмжинэ.

1.3.4 “Алтай бидний нийтийн гэр” Олон улсын Зөвлөлийн үйл ажиллагаанд оновчтой оролцож, гадаадад аймаг орноо сурталчлан таниулах, аялал жуулчлал, хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

1.3.5 Гуравдагч орнуудын муж, хотуудтай хамтран ажиллах харилцааг нэмэгдүүлнэ.

### **1.4. Батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх талаар**

1.4.1 “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”-ийг орон нутагт сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна.

1.4.2 Цэрэг татлага, цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг чанартай явуулж, цэргийн дайчилгааны бэлтгэл үүрэгтний давтан сургалтууд, дайчилгааны сургууль, цугларалтыг төлөвлөгөөний дагуу үр дүнтэй зохион байгуулна.

1.4.3 Аймгийн Батлан хамгаалах газрын “Командын байр”, “Цугларах”, “Шилжүүлэх” байруудыг тодотгож, томилгоот бүрэлдэхүүнтэй дадлага хийлгэж хэвшүүлнэ.

1.4.4 Дайчилгааны даалгавраар тогтоосон хүнс, шатах тослох материал, эд хөрөнгийн нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангах, нөөцийн бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1.4.5 Орон нутгийн хамгаалалтын үйл ажиллагааг төлөвлөн, зохион байгуулна.

1.4.6 Аймаг, сумын удирдлагуудыг Батлан хамгаалах яам, ЗХЖШ-аас явуулах цэрэг, стратегийн сургалтанд хамруулна.

### **Хоёр. Нийгмийн бодлогын хүрээнд:**

#### **2.1. Боловсрол, соёл, биеийн тамир спортын чиглэлээр:**

2.1.1. Сургуулийн бүтэц, хэв шинж хамран сургах тойргийг шинэчлэн мөрдүүлж хамран сургалтыг нэмэгдүүлнэ.

2.1.2. "Хүүхэд бүр цэцэрлэгт" хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, хувийн цэцэрлэгийн үйл ажиллагааг дэмжиж, хамран сургалтыг нэмэгдүүлнэ.

2.1.3. Насан туршийн боловсролын дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, дүйцсэн хөтөлбөрийн суралцагчдыг "Үдийн цай хөтөлбөрт" хамруулах боломжийг судална

2.1.4. Дотуур байрны эрүүл, аюулгүй орчны стандартыг боловсруулан мөрдүүлж, 6-8 настай хүүхдэд зориулсан асаргаа халамж хөгжлийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

2.1.5 Боловсрол соёл урлагын газрын мэргэжилтнүүдийг чадавхжуулж, сургалт арга зүйн судалгаа шинжилгээний ажлыг өргөжүүлэн, сургууль, багш нарын тэргүүний арга технологийг судлан, түгээн дэлгэрүүлнэ.

2.1.6. "Сургууль –хүний хөгжлийн төв " дэд хөтөлбөр батлуулж хэрэгжүүлнэ.

2.1.7. Боловсролын үйл ажиллагаанд нийгмийн эгэх хариуцлагыг нэвтрүүлж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.1.8. Орон нутгийн онцлогтой уялдуулан "Номын гэгээ" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, Америкийн нэгдсэн улсаас хэрэгжүүлж байгаа багшийн мэргэжил дээшлүүлэх "Ментор", "Аксес" хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.1.9. Ахлах ангийн сурагчдын сонгон суралцагчдын арга зүйг боловсруулан хэрэгжүүлж, элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээг ахиулна.

2.1.10. Багш, хүүхдүүдийн ур чадвар, авьяасыг нээн илрүүлэх, эрүүл мэндийг сайжруулах зорилго бүхий "Чадварлаг Ховдчууд" хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлнэ.

2.1.11. Сургууль, цэцэрлэг соёлын байгууллагуудын мэдээлэл харилцааны технологийн тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлж, өндөр хурдны интернетээр холбоно.

2.1.12. Боловсрол соёл, урлагын газрыг конторын байртай болгоно.

2.1.13. Жаргалант сумын I, XV, Булган сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулна.

2.1.14. Манхан сумын спорт цогцолборыг ашиглалтанд оруулна.

2.1.15. "Хөгжил" политехник коллежид техник технологийн шинэчлэл хийж, сургалтын хөтөлбөрийг нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцүүлэн шинэчилж, өргөжүүлнэ.

2.1.16. Жаргалант суманд 600 хүүхдийн сургууль, 150 хүүхдийн цэцэрлэгийн цогцолбор, Мянгад сумын цэцэрлэгийн барилгын ТЭЗҮ боловсруулна.

2.1.17. Дарви, Цэцэг, Булган сумын 2-р сургуулийн хичээлийн байр, Жаргалант сумын 3-р сургуулийн их засвар, гадна тохижилтын ажлыг хийнэ.

2.1.18. Алтай сумын цэцэрлэгийн Жаргалант сумын 10 дугаар цэцэрлэгийн барилгын өргөтгөж, 11-р цэцэрлэгийн барилгыг засварлана.

## **2.2. Эрүүл мэндийн чиглэлээр:**

2.2.1. Иргэдийг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг шинжилгээнд явуулын хэлбэрээр хамруулж өвчлөлийг эрт илрүүлж, эмчлэх арга хэмжээг авна.

2.2.2. Осол гэмтэл, амны хөндий, эмийн хэрэглээ, хавдар зэрэг иргэдийн эрүүл мэндэд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийн судалгааны ажлыг хийж, цаашид хийх ажлыг төлөвлөн хэрэгжүүлнэ.

2.2.3. “Эрүүл мэндийн эрсдлийг бууруулах” хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ.

2.2.4. Амьсгалын замаар дамжих халдварт өвчин, ялангуяа улаан бурхан, улаанууд зэрэг өвчний дархлаажуулалтын хамралтыг сайжруулж, өвчлөлийг бууруулна.

2.2.5. Эрүүл мэндийн салбарт хэрэгжих гадаад, дотоод төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулан үр дүнг дээшлүүлнэ.

2.2.6. Эх, хүүхдийн тусламжийн чанарыг сайжруулах “Эх хүүхдийн ээлтэй тусламж үйлчилгээ” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2.7. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, устгалын журмыг хэрэгжүүлж, хог хаягдлын байгууламжийг шинээр байгуулж ашиглана.

2.2.8. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн “Оношилгооны төв”-ийн барилгыг барьж эхлүүлнэ.

2.2.9. Булган сумын Нэгдсэн эмнэлгийн барилгыг ашиглалтанд оруулж, Жаргалант сумын эмнэлэг (Хүүхдийн эмнэлэг)-ийг байгуулна.

2.2.10. Рашаант, Баатархайрхан өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгыг барина.

2.2.11. Цэцэг сумын Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийн зураг төсвийг хийлгэж, Эрүүл мэндийн газрын болон Эрдэнэбүрэн сумын Эрүүл мэндийн төвийн барилгыг засварлана.

2.2.12. Мянган угалзат Орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газрын барилгын өмчлөлийн болон засвар, урсгал зардлын санхүүжилтийг шийдвэрлүүлж, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн амбулаторийн үйлчилгээг явуулна.

2.2.13. Эрүүл мэндийн байгууллагуудын эрэлт хэрэгцээнд үндэслэн эмнэлгүүдийн нэн шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх, хатуу зөөлөн эдлэлийг шинэчлэх “Үйлчлүүлэгчийн ээлтэй орчин” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

### **2.3. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр**

2.3.1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх замаар 500 хүнийг ажлын байртай болгоно.

2.3.2. “Зөв залуу хүн” залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

2.3.3. “Өрх толгойлсон эх/ эцэг/-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.3.4. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг сайжруулах” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.3.5. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлын ажиллах нөхцөл, иргэдэд үйлчлэх эрүүл ахуйн шаардлага хангасан орчинг сайжруулна.

2.3.6. Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах арга хэмжээг орон нутгийн онцлог байдалд зохицуулан хэрэгжүүлнэ.

2.3.7. Жендерийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.3.8. Нэвтийн амралтыг ахмадын рашаан сувилал болгон өргөжүүлж, иргэдэд хөнгөлөлттэй нөхцлөөр үйлчлэх боломжийг бүрдүүлж Хүүхдийн Баянбулаг зуслангийн үйл ажиллагааг жигдрүүлнэ.

2.3.9. Ахмадын ордны үйл ажиллагааг өргөжүүлж ахмадын чөлөөт цагийг өнгөрүүлэх хөгжлийн төвтэй болгох, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврээр хөнгөлөлттэй үнээр үйлчилнэ.

2.3.10. “Гэр бүлийн хөгжил, хамгааллыг дэмжих” дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

2.3.11. Хүүхдийн ордны барилгыг засварлаж хэвийн үйл ажиллагааг хангана.

2.3.12. “Гэрэлт ирээдүй-Хадгаламж” бүтэн өнчин хүүхдэд тэтгэлэг олгох арга хэмжээг авна.

#### **2.4. Соёл урлагийн чиглэлээр:**

2.4.1. Соёлын биет болон биет бус өвийн нэгдсэн цахим сантай болгож, соёлын өвийг хадгалан хамгаалж, өвлүүлэн хөгжүүлнэ.

2.4.2. Орон нутгийн дэмжлэгтэйгээр “Олон үндэстэн ястаны өв соёл” дэд хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлнэ.

2.4.3. Соёл урлагийн салбарын хүрээнд хөрш зэргэлдээ орнуудтай хамтын ажиллагааг бэхжүүлж, гадаад харилцааг өргөжүүлж, ажилчдыг олон улс, улс, бүсийн уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлнэ.

2.4.4. Номын сангийн номын фонд, уншигчдын тоог нэмэгдүүлнэ.

2.4.5. Орон нутгийн дэмжлэгтэйгээр Нийтийн номын санд “Оюун түлхүүр” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

2.4.6. “Цахим номын сан” болон сумдын номын сангийн үйл ажиллагааг өргөжүүлж, Америкийн мэдээллийн төвтэй хамтран ажиллана.

2.4.7. Манхан сумын спортын цогцолборыг ашиглалтанд оруулж, Мөнххайрхан, Дарви, Булган сумдын соёлын төвүүдийг засварлана.

#### **2.5. Биеийн тамир, спортын чиглэлээр:**

2.5.1. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх, олон улс, тив дэлхийн уралдаан тэмцээнд оролцох тамирчдыг дэмжих зорилгоор “Спортын аварга” хөтөлбөрийг хэрэгжүүлж, тамирчид, дасгалжуулагчдыг урамшуулах журмыг шинэчлэн боловсруулна.

2.5.2. Олон улсын болон улсын аварга шалгаруулах тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулж, тамирчид, дасгалжуулагчдын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, олон улс, улс, бүсийн хамтын үйл ажиллагааг бэхжүүлнэ.

2.5.3. Усан бассейн, спортын ордны бага заалны засварыг хийж үйл ажиллагааг тогтмолжуулан, орон нутгийн иргэдийг усан спортоор хичээллэх нөхцлийг бүрдүүлнэ.



3.1.19 Эдийн засгийн үр ашигтай, төсөл хөтөлбөрийг сурталчлан дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах үйл ажиллагааг зохион байгуулна.

3.1.20 Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн оновчтой хэлбэрийг ашиглан зохион байгуулж, харилцан ашигтай хамтын ажиллагааг дэмжинэ.

## **3.2 Хөдөө аж ахуйн талаар:**

3.2.1. Аймагт сайжруулагчаар ашиглаж буй үүлдэр, үүлдрийн хэсэг, омгийн малын үржил селекцийн ажлыг сайжруулах “Шилмэл мал” дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.

3.2.2. Сутай омгийн хонийг үүлдрээр, Мянгад суманд үржүүлж буй Мянгад адууг омгоор баталгаажуулж Торгууд хонийг сайжруулагчаар ашиглана.

3.2.3. Баталгаажсан үүлдэр, омгийн малын стандартын шаардлага хангасан хээлтүүлэгч бойжуулах цөм сүргийн үржлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжинэ.

3.2.4. Аймгийн шилмэл малын үзэсгэлэн худалдааг зохион байгуулна.

3.2.5. Мал сүргийг бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах, шилмэл малын мэдээллийн санд баяжуулалт хийж, мал ээмэгжүүлэх, бүртгэлжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.

3.2.6. Тэмээн сүргийн тоо толгойг өсгөх болзол журам батлуулж, ингэний сүү, хоормогийг үндэсний тохирлын тэмдэгтэй болгох ажлыг эхлүүлнэ.

3.2.7. Сарлагийн тоо толгойг өсгөн үржүүлэх бодлого гаргаж, зэргэлдээ аймаг, сумдаас сарлагийн өсвөр хээлтүүлэгч авч сайжруулагчаар ашиглахад судалгаа гаргаж ажиллана.

3.2.8. Жимс, жимсгэнэ тариалалтыг нэмэгдүүлж, тариалах иргэдийн санал санаачилгыг дэмжинэ.

3.2.9. Сумдад мал угаах суурин ванныг шинээр барих ажлыг үе шаттайгаар зохион байгуулах ажлыг эхлүүлнэ.

3.2.10. Тариаланчдыг бордооны зүй зохистой хэрэглээний сургалтанд хамруулж, хяналт тавина.

3.2.11. Мал аж ахуй эрхэлж буй малчин залуучуудыг дэмжих “Залуу малчин” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.2.12. Эрчимжсэн мал аж ахуйн бүс нутгийг аймаг, сумын түвшинд тогтоож мөрдүүлнэ.

3.2.13. Нутгийн малын ашиг шимийн түвшинг тогтоох үзлэг, ангилалтыг жил бүр хийж, үржлийн ажлын бодлого чиглэлийг тодорхойлно.

3.2.14. Сум бүр бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулан, мөрдүүлж, бэлчээр ашиглалтыг сайжруулна.



3.2.15. Бэлчээрийн хортон шавжтай тэмцэх арга хэмжээг жил бүр зохион байгуулж, шинээр хортон шавж, мэрэгч тархаж байгаа газар нутгийн судалгаа гаргаж, тархацыг бууруулна.

3.2.16. Хадлан, тэжээл бэлтгэх болзол журам гаргаж, хадлангийн механикжсан салаа байгуулах, техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг эхлүүлнэ.

3.2.17. Хавар намрын угаалга, туулга, боловсруулалт, хашаа хороо, өтөг бууцын ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмолжуулна.

3.2.18. Эрдэнэбүрэн сумын услалтын системийг сэргээж, Алтай, Булган, Буянт, Дарви, Үенч сумдад усалгаатай газар тариалан эрхлэлтийг нэмэгдүүлэх ажлыг эхлүүлнэ.

### **3.3 Үйлдвэрлэл, худалдааны талаар:**

3.3.1 Малыг үйлдвэрийн аргаар нядалж, махыг ангилж, савлах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулах санал санаачилгыг дэмжинэ.

3.3.2 Сумдад бүсчилсэн ноос угаах, эсгий үйлдвэрлэх цех байгуулахад хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ.

3.3.3 Хог хаягдлыг багасгаж, дахин боловсруулах жижиг дунд үйлдвэр байгуулах санал санаачилгыг дэмжинэ.

3.3.4 Ажлын болон хөдөлмөр хамгааллын хувцас нийлүүлэгчээр ажиллах оёдлын үйлдвэрүүдийг дэмжинэ.

3.3.5 Хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангуулж, хэрэглэгчдийг баталгаат хүнсээр хангана.

3.3.6 Аймгийн “Брэнд бүтээгдэхүүн”-ийг шалгаруулах журам батлуулж, хэрэгжүүлнэ.

3.3.7 Хоршооны гишүүн малчин өрхийн үйлдвэрлэл эрхлэх боломжийг нэмэгдүүлж, экологийн цэвэр брэнд бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлнэ.

### **3.4 Дэд бүтцийн талаар:**

3.4.1 Концессын гэрээгээр хийгдэж буй Хэвтээ тэнхлэгийн Алтай хот-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто замыг ашиглалтанд оруулна.

3.4.2 Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Булган-Үенч чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замын төслийг гүйцэтгэж ашиглалтанд хүлээн авна.

3.4.3 Мөст, Эрдэнэбүрэн сумын төвийг Босоо тэнхлэгийн авто замтай холбох ажлыг эхлүүлнэ.

3.4.4 Булганы Байтаг боомтын хүчин чадлыг нэмэгдүүлж, үйлчилгээг өргөжүүлэн хатуу хучилттай авто замаар холбох ажлыг эхлүүлнэ.

3.4.5 Ховд хот дотор 10 км хатуу хучилттай авто зам барих ажлыг эхлүүлнэ.

3.4.6 Хот доторх хатуу хучилттай авто замын дагуу явган хүний замын уртыг нэмэгдүүлнэ.

3.4.7 Аймгийн төв рүү орох, төвөөс гарах гурван чиглэлийн зам, Эрдэнэбүрэн сумын Хонгио, Манхан сумын гурван замын бэлчир, Булган суманд авто тээврийн

шалган нэвтрүүлэх бүрэн тоногдсон пост ажиллуулж тээврийн хэрэгсэлийн даацын хяналтыг тавьж, авто замын ашиглалтыг сайжруулна.

3.4.8 Сумын төвийн гэрэлтүүлэг, авто зам, тохижилтын ажил (Мянгад, Манхан, Ховд, Мөст, Чандмань, Эрдэнэбүрэн сумд)-ын төслийг гүйцэтгүүлж ашиглалтанд авна.

3.4.9 Хот доторх автобусны зогсоолуудыг тохижуулж, нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл, давтамжийг нэмэгдүүлнэ.

3.4.10 Аймгийн төвөөс сумдын чиглэлийн зорчигч, ачаа тээвэр, шуудангийн үйлчилгээний менежментийг сайжруулж, Жаргалант, Булган сумдад авто вокзалын үйлчилгээг эхлүүлнэ.

3.4.11 Олон улсын чанартай авто замын дагууд авто тээврийн үйлчилгээний төв байгуулах аж ахуй нэгж хувийн хэвшлийг дэмжинэ.

3.4.12 Чандмань сумын чиглэлд хатуу хучилттай зам тавих ТЭЗҮ боловсруулна.

3.4.13 Жаргалант, Булган суманд тээвэр ложистикийн төв байгуулах ажлыг эхлүүлнэ.

3.4.14 Орон сууц нийтийн үйлчилгээний контор байгуулж нийтийн орон сууцны засвар үйлчилгээ болон ашиглалтыг сайжруулна.

3.4.15 Аймгийн цахилгаан эрчим хүч хэрэглэгчдэд орчин үеийн ухаалаг тоолуур суурилуулж, цахилгааны төлбөрийг хугацаанд нь барагдуулах ажлыг эхлүүлнэ.

3.4.16 Нийтийн орон сууцны орц, дээвэр, гадна орчны тохижилт, хэрэглээний халуун усны шугамыг үе шаттайгаар засварлана.

3.4.17 Хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлж захиалагчийн хяналтыг хэрэгжүүлнэ.

3.4.18 Цэвэр, бохир усны шугамыг шинэчлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

3.4.19 Цэвэрлэх байгууламжийг цахилгааны нөөц эх үүсвэртэй болгоно.

3.4.20 Дөргөн суманд ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулна.

3.4.21 Өв соёлын “Маануус” цэцэрлэгт хүрээлэн, ардын соёл урлагын “Икэл” цогцолбор, битүү хөлбөмбөгийн талбайн ТЭЗҮ боловсруулах

3.4.22 Манханаас Хөшөөт хүртэлх 110кВ-ын Цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлыг эхлүүлнэ.

3.4.23 “Хөшөөт хөгжлийн гарц” төсөл хэрэгжүүлж, харилцан ашигтай байдлаар хамтран ажиллаж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

3.4.24 Газрын тосны эрэл, хайгуулын ажилд хяналт тавьж ажиллана.

### **3.5. Барилга хот байгуулалт, Газрын харилцааны талаар:**

3.5.1 Аймгийн хэмжээнд өмчлүүлэх боломжтой нөөц газруудыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж иргэдэд газар өмчлүүлнэ.

3.5.2 Иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллагуудад үйлдвэр үйлчилгээний зориулалтаар газрыг дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгоно.

3.5.3 Улсын болон орон нутгийн чанартай баталгаажсан зам, орон нутгийн зам, гудамж, талбай, үл хөдлөх хөрөнгийн судалгаа гаргаж, хаягийн зураг хийж,

зураглалын дагуу хаягийн тэмдэг, тэмдэглэгээг байршуулж, хаягийн давхардалтыг арилгаж нэгдсэн стандартад шилжүүлэх ажлыг эхлүүлнэ.

3.5.4 Зарим сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийж түүнд үндэслэн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хийнэ.

#### **Дөрөв. Байгаль орчны бодлогын хүрээнд:**

##### **4.1 Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлал:**

4.2.1 Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн үзэл санааг бүх шатны сургалтын хөтөлбөрөөр дамжуулан байгаль хамгаалах уламжлалт ёс заншлаа өвлүүлэх, арвилан хэмнэх чиг хандлага, сэтгэлгээ зан үйлийг төлөвшүүлнэ.

4.2.2 Нэн ховор, ховор амьтан, ургамлын тархац нутаг, усны эх, байгалийн үзэсгэлэнт өвөрмөц тогтоцтой, түүхийн дурсгалт газрыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтанд авах ажлыг зохион байгуулна.

4.2.3 Тахь, Хар сүүлтий, Бөхөн, Хулан зэрэг амьтдын судлагдсан байдал, хамгаалалтын талаар хийгдсэн ажлыг нэгтгэж мэдээллийн сан бүрдүүлнэ.

4.2.4 Аймгийн нутаг дэвсгэрт агнуур зохион байгуулалтын судалгааг хийлгэж, ан амьтдын байршил, нөөцийг тогтоосны үндсэн дээр зохистой ашиглалтын ажлыг эхлүүлнэ.

4.2.5 Хөрсний үржил шим, ургамлын доройтол, цөлжилтийн хэмжээг тодорхойлж, ойн санг нэмэгдүүлж, 30 га-аас доошгүй талбайд мод тарьж, ойжуулна.

4.2.6 Наран, Рашаант, Цамбагарав багийн хөрсний цэвдэгшилтийг бууруулах ажлыг эхлүүлнэ.

4.2.7 Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хувиараа ашигт малтмал олборлож буй иргэдийг албажуулах, зохион байгуулалтад оруулах замаар байгаль орчныг хамгаалах хариуцлагыг нэмэгдүүлнэ.

4.2.8 Хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг хөгжүүлж, нөхөн сэргээлт, биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалалтыг сайжруулан хуримтлагдах нөлөөллийг бууруулна.

4.2.9 Хот суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, бичил цэцэрлэгт хүрээлэнг шинээр байгуулна.

4.2.10 Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжинэ.

4.2.11 Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгоно.

4.2.12 Ховд хотын агаарын бохирдлыг бууруулах, бүрэн шаталттай ахуйн хэрэгцээний стандартын зуухыг орон нутагт нийлүүлэх ажлыг зохион байгуулна.

4.2.13 Аймгийн агаарын бохирдлыг бууруулах талаар эрх зүйн баримт бичгийг гаргаж мөрдөн ажиллана.

4.2.14 Гурван сэнхэр төвтэй “5 од” хөтөлбөр хэрэгжүүлж, олон үндэстэн, ястны ахуй соёл, зан заншил, уламжлал, түүх, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар гадаад, дотоодын аялагчдын тоог нэмэгдүүлнэ.

4.2.15 Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг дэмжинэ.